

**Монгол улсын харъяатаас гарахыг хүсэгч нь дор дурдсан
бичиг баримт бүрдүүлнэ:**

1. Өргөдөл. Хоёр хувь гараар бичсэн байна. Өргөдлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр дээр гаргана. Өргөдөлд Монгол Улсын харъяатаас гарах болсон шалтгаан, Монгол улс болон гадаад улсад ямар хугацаагаар аж төрж, ажиллаж, суралцаж байсан, аль улсын харъяат болох хүсэлтэй байгаа, эцэг, эх, эхнэр (нөхөр), хүүхэд нь аль улсын харъяат, тэд одоо хаана, юу эрхэлж байгаа, хүүхэдтэй бол хэзээ, хаана төрсөн, аль улсын харъяат байлгах талаар эцэг (эх)-тэй нь тохиролцсон тухай тодорхой тусгана.

2. Гурван үеийн намтар (өвөг эцэг, эцэг, өөрийн намтар)

3. Анкет бөглөх.

4.1. 16 хүртэл насны хүүхдийнхээ иргэний харъяаллыг өөрчлөх бол энэ талаар эцэг, эхийн бичгээр гаргаж, гарын үсгийг нотариатаар гэрчлүүлсэн тохиролцоо.

4.2. Харъяатаас гарахыг зөвшөөрсөн эцэг, эхийн тодорхойлолт. Тодорхойлолтод эцэг эх нь гарын үсэг зурах ба иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргана. Эцэг, эх нь нас барсан бол нас барсан тухай Монгол улсын холбогдох байгууллагын тодорхойлолт.

5. Өөрийн болон 16-18 насны хүүхдийн иргэний үнэмлэх (паспорт), 16 хүртэлх насны хүүхдийн төрсний гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, төрсөний гэрчилгээ гадаад хэлээр бол орчуулга.

6. Иргэний харъяаллаа өөрчлөх тухай хүүхдийн өөрийнх нь бичгээр гаргаж, гарын үсгийг нотариатаар гэрчлүүлсэн санал.

7. Гэрлэлтийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, гэрлэлтээ цуцлуулсан бол энэ тухай эрх бүхий байгууллагаас гаргасан албан ёсны шийдвэрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, Гэрлэлтээ гадаадад бүртгүүлсэн бол гэрлэлтийн гэрчилгээний орчуулга.

8. Монгол улсын иргэний харъяаллаас гарсан тохиолдолд өөрийн харъяаллыг олгохыг зөвшөөрсөн гадаад улсын эрх бүхий холбогдох байгууллагын албан ёсны зөвшөөрөл, орчуулгын хамт.

9. Монгол Улсад иргэний өр төлбөр, нэхэмжлэлгүй болох талаар дараах байгууллагаас гаргасан тодорхойлолт:

9.1 Шүүх (нийслэлийн шүүх, орон нутгийн шүүх)

9.2 Цагдаагийн байгууллага (ЦЕГ)

9.3 Банкны өр барагдуулах алба

9.4 Татварын байгууллага (нийслэлийн дүүрэг, орон нутгийн татварын байгууллага)

9.5 Сургалтын төрийн сан (БСШУЯ)

10. Ажил эрхэлдэг, цалин, орлоготой болох тухай ажил, тэтгэлэг олгогчийн нотолгоо, тодорхойлолт, орчуулгын хамт.

11. Өргөдлийн хураамж төлсөн баримт-100 евро.

Дээр заагдсан бичиг баримтын хуулбар, гарын үсэг баталгаажуулахад бичиг тус бүрт 10 евро төлнө.

12. Гэрэл зураг 5 хувь.

13. ЭСЯ-ны тодорхойлолт (Материалаа бүрдүүлж ЭСЯ-ны консулын хэлтэст өгсөний дараа консулын хэлтэс бичгээр үйлдэж, материалын хамт ГИХАЭА-нд хүргүүлнэ)

эдгээр болно.